Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад бараа материалын бүртгэлтэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Аудитын хоёрдугаар газрын ахлах аудитор Б.Энхжин, аудитор Ж.Нямцэцэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Ц.Хосжаргал, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 36 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг нь 2021 онд “Хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэдний эрэлт, хэрэгцээнд тулгуурлан аливаа өвчнөөс урьдчилан сэргийлэх, нотолгоонд суурилсан оношилгоо, эмчилгээний шинэ технологийг нэвтрүүлэх, эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн зохистой тогтолцоог бүрдүүлэх замаар тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан монгол хүний дундаж наслалтыг уртасгахад оршино” гэсэн зорилгын хүрээнд 67 арга хэмжээ төлөвлөж, дараах 12 зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна.

- Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн үндэсний эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдэж, өдөр тутмын оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг бүрэн нэвтрүүлэх;
- Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн тусламж, үйлчилгээнд “Ухаалаг эмнэлэг хөтөлбөр” хэрэгжүүлэх, Эрүүл мэндийн зан үйл, дадал хэвшлийг бий болгож, үйлчлэх хүрээний хүн амын эрүүл мэндийн боловсрол дээшлүүлэх, ажлын байранд эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа төлөвлөж, хэрэгжүүлэх;
- Оношилгооны шинэ технологийн тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх;
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээнд дэвшилтэт технологийг нэвтрүүлэх, нутагшуулах;
- Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулж, JCI олон улсын магадлан итгэмжлэгдсэн эмнэлэг болох;
- Антибиотик нянгийн тэсвэржилт үүсэхээс сэргийлэх, хянах, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, чанартай эм эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангах, эмнэлгийн тоног, төхөөрөмжийн засвар үйлчилгээг сайжруулах, шинээр суурилуулах;
- Чадахуйн зарчимд суурилсан хүний нөөцийг бүрдүүлж, салбарын санхүүгийн чадавх, менежментийг сайжруулах;
- Сургалтын үйл ажиллагаанд түшиц эмнэлэг болох, эрүүл мэндийн ажилтны ур чадварыг тасралтгүй дээшлүүлэх;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрсдэлийн удирдлагаар хангах;
- Салбарын инновац, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын үр дүнг практикт өргөнөөр нэвтрүүлэх;

- Эмнэлгийн үйл ажиллагааг олон нийтэд, таниулах, иргэдийн эрүүл мэндийн мэдлэг, хандлагыг сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулах;
- Байгууллагын ил тод байдлыг хангах;

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд голлон мөрдөх дараах хууль, тогтоомж, бодлого чиглэлд өөрчлөлт орсон. Үүнд:

- Эрүүл мэндийн тухай хууль,
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”,
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирлын 2020 оны А/151 тушаалаар баталсан тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэгт дотоод аудитын нэгж байхгүй бөгөөд 2018 онд дотоод аудитын журам баталсан ба тус журамд аудиторын хараат бус байдал, аудитын үйл ажиллагааны талаар тодорхой тусгасан байна. Эмнэлгийн захирлын 2021 оны Б/11 тушаалаар гэрээгээр дотоод аудитор томилон ажиллуулсан байна. Дотоод аудитор нь 3 төрлийн 11 үйл ажиллагаанд горим сорил хэрэгжүүлэн, аудитын үйл ажиллагааг гүйцэтгэж холбогдох хэлтсүүдэд зөвлөмж хүргүүлсэн ба 10 зөвлөмж бүрэн хэрэгжиж, 1 зөвлөмж биелэлт ирүүлэх хугацаа болоогүй талаар аудитын тайлан гаргасан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитороос шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 16,655,229.2 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 166,552.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Аудитын гүйцэтгэх үе шатанд 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн суурь үзүүлэлтээс материаллаг байдлын түвшинг тооцоход төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлаас 13.0 хувиар нэмэгдсэн байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзэн материаллаг байдлыг 191,397.2 мянган төгрөгөөр тооцов.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,133,972.1 мянган төгрөгөөр буюу 2.5 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, хуримтлагдсан үр дүнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Мөнгөн хөрөнгө	128,478.6	209,854.2	81,375.6
Авлага	228,593.2	3,676,185.2	3,447,592.0
Урьдчилгаа	194,850.0	-	(194,850.0)
Бараа материал	3,487,987.6	3,332,496.0	(155,491.6)
Үндсэн хөрөнгө	40,486,901.3	36,174,303.2	(4,312,598.1)
Нийт хөрөнгийн дүн	44,526,810.7	43,392,838.6	(1,133,972.1)
Нийт өр төлбөр	52,005.1	49,213.5	(2,791.5)
Засгийн газрын хувь оролцоо	44,474,805.6	43,343,625.1	(1,131,180.6)
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	44,526,810.7	43,392,838.6	(1,133,972.1)

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 209,854.2 мянган төгрөг болж өмнөх оноос 81,375.6 мянган төгрөгөөр өссөн нь ахмадын сан болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажлын барьцаа хөрөнгө данс нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Авлага дансны үлдэгдэл 3,676,185.2 мянган төгрөг болж өмнөх оноос 3,447,592.0 мянган төгрөгөөр өссөн нь Эрүүл мэндийн даатгалын сангаас 2021 оны гүйцэтгэлээр санхүүжигдэх санхүүжилтийн авлага 2,470,848.5 мянган төгрөг, тайлант онд үүссэн 1,160,090.8 мянган төгрөгийн татаас санхүүжилтийн авлагын өсөлтөөс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 3,332,496.0 мянган төгрөг болж 155,491.6 мянган төгрөгөөр буурсан нь бараа материалын дансанд бүртгэлтэй 111,234.7 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр үндсэн хөрөнгийн дансанд шилжүүлэн бүртгэсэнээс шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын шийдвэрээр 226,694.2 мянган төгрөгийн акталсан хөрөнгийн дүн, 3,421,624.8 мянган төгрөгийн үнэ бүхий цаашид ашиглах боломжгүй MRI аппаратын элэгдлийг нөхөн тооцож залруулсан дүнгээр хасагдаж, үлдэх өртөггүй 398,536.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоосон, 8,445.0 мянган төгрөгийн бараа материалыг үндсэн хөрөнгийн данснаас шилжүүлснээс нэмэгджээ.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 43,343,625.1 мянган төгрөг болж өмнөх оноос 1,131,180.6 мянган төгрөгөөр буурсан нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтөөр 1,820,349.6 мянган төгрөгийн элэгдлийг өмнөх үеийн үр дүн рүү залруулсан дүнгээр хасагдсан, тайлант үеийн үр дүн 689,169.0 мянган төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар үйл ажиллагааны орлогын дүн 19,829,920.4 мянган төгрөг болж өмнөх оноос 5,516,947.6 мянган төгрөгөөр буюу 27.8 хувиар, нийт зардал өмнөх оноос 15,736,207.9 мянган төгрөг болж өмнөх оноос 2,456,827.4 мянган төгрөгөөр буюу 6.4 хуваарь тус тус өссөн үзүүлэлттэй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Төрийн тусгай албан хаагчдын эмнэлэг нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 17,688,047.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвөөс зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зардлыг 1,563,371.9 мянган төгрөгөөр бууруулж нийт 16,124,675.7 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг нь тайлант онд 1 хөтөлбөрийн 5 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 16,124,675.7 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 5,811,731.4 мянган төгрөгийг улсын төсвөөс, 9,092,257.5 мянган төгрөгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас, 1,220,686.8 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 5,811,731.3 мянган төгрөг, Эрүүл мэндийн даатгалын сангаас 9,226,649.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 765,054.6 мянган төгрөг, нийт 15,719,871.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлсэн байна.

Үндсэн үйл ажиллагааны орлогоос 765,054.6 мянган төгрөгийг бүрдүүлж, орлого 455,632.2 мянган төгрөгөөр тасарсан нь короновируст цар тахлын улмаас эмнэлгээр үйлчлүүлэгчдийн тоо буурсан, урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо, шинжилгээ хийгдээгүй зэргээс шалтгаалсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 14,596,052.1 мянган төгрөг буюу 90.5 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг 635,196.0 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 222,913.3 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 36,347.9 мянган төгрөгөөр, эд хогшил, урсгал зардлыг 36,630.7 мянган төгрөгөөр бараа ажил үйлчилгээний бусад зардлыг 597,028.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Улсын төсвийн санхүүжилтээс 83,563.6 мянга, эрүүл мэндийн даатгалын санхүүжилтээс 1,123,819.5 мянган төгрөгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлж, татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөг/

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71602	Эмнэлгийн тусламж үйлчилгээ	16,124,675.7	14,596,052.1	1,528,623.6	90.5
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	10,142,632.6	9,244,390.7	898,241.9	91.1
1.2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал дэмжлэг	327,441.8	327,441.8	-	100.0

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

1.3	80810	Нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулал	34,550.0	34,486.0	64.0	99.8
1.4	81601	Өндөр өртөгтэй мэс заслын зардал	1,807,733.3	1,210,704.7	597,028.6	67.0
1.5	81613	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	3,812,318.0	3,779,028.9	33,289.1	99.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 688,569.2 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 129,500.0 мянган төгрөг, нийт 818,069.2 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, урсгал засварын зардалд 192,297.8 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийхэд 5,000.0 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд 455,000.0 мянган төгрөг, эмнэлгийн тусламж үйлчилгээнд ашиглах түргэний тэрэг худалдан авах зардалд 129,500.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Асуудлын онцолсон хэсэг

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг нь 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлого “Алсын хараа-2050”, Төрөөс эрүүл мэндийн талаар баримтлах бодлого 2017-2026, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр 2020-2024, Монгол Улсын Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөр/18/, Хууль зүй, дотоод хэргийн яамны стратеги төлөвлөгөө, Эмнэлгийн дунд хугацааны стратеги төлөвлөгөө 2021-2024 зэрэг бодлогын баримт бичгүүдийн хүрээнд 1 хөтөлбөр 4 арга хэмжээг хэрэгжүүлэхээр 12 зорилтын хүрээнд 67 ажил хийхээр төлөвлөж, 96.8 хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг нь Ковид-19 цар тахлын өвчлөлтэй үед бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор Улсын онцгой комиссын шийдвэрээр коронавирусын халдвартай иргэнд тусламж үйлчилгээ үзүүлэх, хэвтүүлэн эмчлэх мэргэжлийн тусламж үйлчилгээг 2021 оны 04 дүгээр сараас эхлэн зохион байгуулж 6,279,725.0 мянган төгрөгийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд хүргэж ажилласан байна.

Эрүүл мэндийн сайдын тушаалаар коронавирусын цар тахлын үед иргэдэд эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж ажилласан эмнэлгийн албан хаагч тус бүрд 1,000.0 мянган төгрөг, нийт 455,000.0 мянган төгрөгийн нэг удаагийн урамшуулал олгосон байна.

3.8 Аудитын гол асуудал

Эрүүл мэндийн салбарын шинэчлэлийн хүрээнд Эрүүл мэндийн тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийн дагуу эрүүл мэндийн байгууллагаас иргэнд үзүүлсэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн 2021 оны 03 дугаар тогтоолоор санхүүжилтийг гүйцэтгэлээр олгохоор шийдвэрлэсний дагуу санхүүжилтийг гүйцэтгэлээр санхүүжүүлж эхэлсэн байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудсанд 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалтуудыг тус тус хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн Шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, мөн тус батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн дараах 3 эрсдэлд горим сорил хэрэгжүүлэхэд хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар 147,153.3 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс 4,895.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 46,225.3 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 96,033.0 мянган төгрөгийн 5 зөвлөмж хүргүүлсэн байна. Тус эмнэлгийн 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 665 тоот албан бичгээр аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг ирүүлсэн ба биелэлтийг хянаж үзэхэд, төлбөрийн актын биелэлт 100 хувь, хүргүүлсэн 2 албан шаардлагын биелэлт 90 хувь, алдаа зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх талаар өгсөн 5 зөвлөмжөөс 4 зөвлөмжийн хэрэгжилт 90 хувь, 1 зөвлөмжийн хэрэгжилт 60 хувь, нийт 87.5 хувийн хэрэгжилттэй гэж үнэллээ.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараагийн аудитаар анхаарах асуудал гараагүй болно.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 91,389.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 75,389.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 16,000.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

4.1 Албан шаардлага

Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээс 16,770.5 мянган төгрөгийн зургийн аппарат, 58,618.5 мянган төгрөгийн цэргийн албан хаагчийн нормын хувцас хэрэглэл бэлтгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6-д "эрүүл мэндийн даатгалын сан" гэж даатгуулагчид эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлийг хуваалцах зорилгоор төр, иргэн, хуулийн этгээдээс төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг", 20 дугаар зүйлийн 20.1-д "Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг доор дурдсан зориулалтаар зарцуулна. 20.1.1 "энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах;" 9.1-д "Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад дараах тусламж, үйлчилгээ хамаарна" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Бараа материалтай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Бараа материалын тайланд 16,000.0 мянган төгрөгийн 2 контентыг тусгаагүйгээр шууд зардалд бүртгэсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 4.15 "Бараа материал гэдэг нь байгууллагын хэвийн үйл ажиллагааны явцад хэрэглэгдэх материал буюу хангамжийн зүйлс, худалдах зориулалтаар хадгалагдаж байгаа (улсын нөөцийн бараа зэрэг) бэлэн бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ, үйлдвэрлэлийн процесст байгаа хагас боловсруулсан бүтээгдэхүүн зэрэг болно" гэж заасныг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Биет бус шинжтэй цахим контентуудыг бараа материалын дансанд бүртгэж, тухайн контентыг ашиглагдахгүй болсон тохиолдолд газрын даргын тушаалаар данс бүртгэлээс хасах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр, аудитын код	Алдаа зөрчлийн товч утга	Аудитын байгууллагын тогтоосон акт, албан шаардлага, өгсөн зөвлөмж, залруулгын товч утга	Нийт алдаа, зөрчлийн		/мянган төгрөгөөр/							
						Үүнээс							
				Тоо	Дүн	Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Санхүүгийн тайлангийн асуудлаар													
1	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг АХГ-2022/336/НА-СТА-ТШЗ	Бараа материалын тайланд 16,000.0 мянган төгрөгийн 2 контентыг тусгаагүйгээр шууд зардалд бүртгэсэн байна.	Биет бус шинжтэй цахим контентуудыг бараа материалын дансанд бүртгэж, тухайн контентыг ашиглагдахгүй болсон тохиолдолд газрын даргын тушаалаар данс бүртгэлээс хасах.	1	16,000.0								
2		Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээс 16,770.5 мянган төгрөгийн зургийн аппарат, 58,618.5 мянган төгрөгийн цэргийн албан хаагчийн нормын хувцас хэрэглэл авсан байна.	Албан шаардлагыг хэрэгжүүлэх, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх	1	75,389.0					1	75,389.0	-	-
Дүн				2	91,389.0					1	75,389.00	1	16,000.0
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн асуудал													
1	Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг АХГ-2022/336/НА-СТА-ТШЗ	Шилэн дансны цахим хуудсанд 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.	Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн оруулж байх.	1								1	
Дүн				1								1	
Нийт дүн				3	91,389.0					1	75,389.00	3	16,000.0



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 44/А0160062
АХГ-0002/336/НА-СТА-ТМЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Эрүүл мэндийн даатгалын сангийн санхүүжилтээс 16,770,500.0 мянган төгрөгийн зургийн аппарат, 58,618,534.7 мянган төгрөгийн цэргийн албан хаагчийн нормын хувцас хэрэглээ бэлтгэсэн байна.


Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.6 "эрүүл мэндийн даатгалын сан" гэж даатгуулагчид эрүүл мэндийн улмаас учирч болзошгүй санхүүгийн эрсдэлийг хуваалцах зорилгоор төр, иргэн, хуулийн этгээдээс төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдүүлсэн мөнгөн хөрөнгийг", 20 дугаар зүйлийн 20.1 "Эрүүл мэндийн даатгалын сангийн хөрөнгийг доор дурдсан зориулалтаар зарцуулна." 20.1.1 "энэ хуулийн 9 дүгээр зүйлд заасан эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг худалдан авах;" 9.1 "Эрүүл мэндийн даатгалын сангаас зардлын төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний багцад дараах тусламж, үйлчилгээ хамаарна" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлж, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, дээрх зөрчлийг арилгаж, албан шаардлагын биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн захирал, Хурандаа Х.Бат-Ирээдүй, Санхүү, хангамжийн албаны дарга, Хошууч Д.Гантуяа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ
Б.ЭНХЖИН
Ж.НЯМЦЭЦЭГ

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264330

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban_Shaardlaga\2022\0225_Auditin_2_Gazar-63.Docx

001080194

